



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/465

Улаанбаатар хот

Тусламж, үйлчилгээний чиглэл, хамрах  
хүрээг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдварын цар тахлын үед тусгаарлах, ажиглах, тусламж, үйлчилгээ үзүүлж байгаатай холбоотойгоор Батлан хамгаалах яамны харьяа Цэргийн төв эмнэлэгт Баянзүрх, Багахангай дүүргийн хүн амд үзүүлж байсан мэс заслын яаралтай тусламж, үйлчилгээг 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэгт шилжүүлсүгэй.

2. “Нийслэлийн Баянзүрх, Багахангай дүүргийн хүн амд мэс заслын яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллага, үйлчлэх хүрээ”-г хавсралтаар баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, Баянзүрх, Багахангай дүүргийн иргэдэд шуурхай, чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэхийг Улсын хоёрдугаар төв эмнэлэг (С.Энхболд), Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэг (Р.Отгонбаяр)-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, нийслэлийн Эрүүл мэндийн газарт үүрэг болгосугай.


САЙД



Т.МӨНХСАЙХАН

• 141201804

Эрүүл мэндийн сайдын  
2020 оны 10 сарын 13 өдрийн 9/ тушаалын  
нэгдүгээр хавсралт 165



Нийслэлийн Баянзүрх, Багахангай дүүргийн  
хүн амд мэс заслын яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх  
эрүүл мэндийн байгууллага, үйлчлэх хүрээ

№	Эрүүл мэндийн байгууллага	Үйлчлэх хүрээ
1	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Багахангай, Баянзүрх дүүргийн 1-8, 9, 11, 14-24, 27, 28-р хорооны хүн ам
2	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Японы эмнэлэг	Баянзүрх дүүргийн 10, 12, 13, 25, 26-р хорооны хүн ам